



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/61/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 260512 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Долгоржав Утас: 261729 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn Ариун төгс оршихуй аудит ХХК-ийн захирал: Г.Баялаг Утас: 99023656 Цахим хаяг: ariuntugsorshihuiaudit@gmail.com</p>
---	---

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.2 Албан шаардлага	16
АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/456
танай _____-ны № _____-т

УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ
ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЭР
БАРИХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Г.ЧУЛУУНБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөө эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 39,932.5 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Төсөл боловсруулах, төсөвт хяналт тавих 25,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажил гүйцэтгэхэд харьцуулалтын арга хэрэглэлгүй шууд гэрээ байгуулж, тендерийн босго үнэ мөрдөөгүй;
- Жолоочийн тооцооны хуудсаар баталгаажуулаагүй 8,000.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дүгээр зүйлийн 16.5.2, 24 дүгээр зүйлийн 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7 дахь заалтуудтай нийцээгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Уг зээлийн үндсэн төлөлт, хүү болон төслийн бүтээн байгуулалтын өртөг 262,700.0 мянган ам.доллар бөгөөд зээлийн эргэн төлөлт нь 2027 оны 01 дүгээр сарын 20-оос эхэлнэ. Тусгайлсан зээлийн хэлэлцээрээр эхний 7 жил үндсэн зээл болон хүүгийн төлбөрөөс чөлөөлөгдөх бөгөөд сард 259.5 мянган ам.доллар төлнө. Үүнтэй холбоотой валютын ханшийн зөрүүний алдагдал үүсэх эрсдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Анхны хаягдал ус хүлээн авах үйл ажиллагаа 2025 оны 7 дугаар сарын 24-ний өдрөөс хойш ахуйн шугамаар өдөр бүр 50,000 м³ хаягдал ус хүлээн авч, хүрээлэн буй орчинд нийлүүлэх усны стандарт болох MNS 4943-2015-ийг бүрэн хангасан ус Туул голд нийлүүлж байна.

Бусад асуудлын хэсэг

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Б/221 тушаалаар Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаал болон 2025 оны 174 дүгээр тушаалыг үндэслэн “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүх ажилтнуудыг ажлаас чөлөөлөгдсөн ба төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа дуусгавар болсон.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	644,974,750,067.54	674,127,718,402.33
33	АВЛАГА	806,948.09	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	748,599.09	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	58,349.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	-
34	УРЬДЧИЛГАА	32,734,111,818.92	10,488,760,002.41
34710	Урьдчилгаа тооцоо	32,734,111,818.92	10,488,760,002.41
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа		
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	
35	БАРАА МАТЕРИАЛ	101,470,800.00	7,138,222.12
35100	Түүхий эд материал		
35110	Тусгай зориулалттай материал		
35400	Хангамжийн материал	9,386,300.00	7,138,222.12
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал		
35430	Сэлбэг хэрэгсэл		
35470	Бусад хангамжийн материал	92,084,500.00	
36	НӨӨЦИЙН БАРАА	612,138,360,500.53	663,631,820,177.80
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	612,138,360,500.53	663,631,820,177.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	119,494,563.81	70,060,648.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	119,494,563.81	70,060,648.63
39200	Биет хөрөнгө	118,092,063.86	69,032,148.72
39201	Барилга, байгууламж, орон сууц		
39202	Хуримтлагдсан элэгдэл		
39203	Авто-тээврийн хэрэгсэл	250,800,000.00	250,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(167,199,999.84)	(208,999,999.80)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	115,668,000.00	115,668,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(115,589,893.90)	(115,668,000.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	74,518,090.00	74,518,090.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,104,132.40)	(47,285,941.48)
393	Биет бус хөрөнгө	1,402,499.95	1,028,499.91
39303	Бусад үндсэн хөрөнгө	3,594,000.00	3,594,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,191,500.05)	(2,565,500.09)
39217	Ном		
39300	Биет бус хөрөнгө		
39301	Програм хангамж		

39302	Хуримтлагдсан элэгдэл		
39303	Бусад биет бус хөрөнгө		
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	645,094,244,631.35	674,197,779,050.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	270,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	270,000.00
41300	Өглөг		
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	270,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	645,094,244,631.35	674,197,509,050.96
51	Засгийн газрын хувь оролцоо		
51100	Засгийн газрын оруулсан капитал		
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
51200	Хуримтлагдсан үр дүн	645,094,244,631.35	674,197,509,050.96
51210	Өмнөх үеийн үр дүн	424,824,825,706.56	645,094,244,631.35
51220	Тайлант үеийн үр дүн	220,269,418,924.79	29,103,264,419.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	645,094,244,631.35	674,197,779,050.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	221,747,695,582.41	30,672,226,334.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	220,298,248,582.41	30,672,226,334.79
120	Нийтлэг татварын бус орлого	220,298,248,582.41	30,672,226,334.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	220,298,213,582.41	29,152,698,334.79
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	29,152,698,334.79
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	220,298,213,582.41	-
120009	Бусад орлого	35,000.00	1,519,528,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,449,447,000.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,449,447,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,449,447,000.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,478,276,657.62	1,568,961,915.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,478,276,657.62	1,568,961,915.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,315,284,331.72	1,345,704,252.35

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	972,173,810.00	964,260,349.66
210101	Үндсэн цалин	972,173,810.00	964,260,349.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,529,726.25	116,911,864.29
210201	Тэтгэврийн даатгалын зардал	121,529,726.25	116,911,864.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,516,621.00	117,047,941.22
210304	Байрны түрээс	108,516,621.00	117,047,941.22
2104	Хангамж, бараа материалын зардал	28,069,441.76	17,426,235.00
210401	Бичиг хэрэг	5,017,850.00	5,289,300.00
210402	Тээвэр, шатахуун	13,200,730.00	8,461,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,906,336.76	2,400,015.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,944,525.00	1,275,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,435,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	-
210604	Урсгал засвар	4,935,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	-	8,320,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	8,320,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,655,032.00	72,303,947.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,655,032.00	72,303,947.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,904,700.71	49,433,915.18
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,904,700.71	49,433,915.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	162,992,325.90	223,257,662.83
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	162,992,325.90	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	162,992,325.90	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	223,257,662.83
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	223,257,662.83
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	220,269,418,924.79	29,103,264,419.61
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	220,269,418,924.79	29,103,264,419.61

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,451,786,000.00	1,519,528,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,339,000.00	1,519,528,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,339,000.00	1,519,528,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	1,519,528,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	1,519,528,000.00
120009	Бусад орлого	2,304,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,449,447,000.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,449,447,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,449,447,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,451,786,000.00	1,519,528,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,451,786,000.00	1,519,528,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,288,793,674.10	1,296,270,337.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	972,917,153.00	964,260,349.66
210101	Үндсэн цалин	972,917,153.00	964,260,349.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,593,331.34	116,911,864.29
210201	Тэтгэврийн даатгалын зардал	82,747,200.00	79,500,067.72
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	9,734,503.00	9,352,949.14
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,774,625.00	4,676,474.57
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	4,867,500.00	4,676,474.57
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	19,469,503.34	18,705,898.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,516,621.00	117,047,941.22
210304	Байрны түрээс	108,516,621.00	117,047,941.22
2104	Хангамж, бараа материалын зардал	24,115,536.76	17,426,235.00
210401	Бичиг хэрэг	3,940,000.00	5,289,300.00
210402	Тээвэр, шатахуун	14,000,000.00	8,461,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,731,336.76	2,400,015.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,444,200.00	1,275,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,792,000.00	-

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	24,857,000.00	-
210604	Урсгал засвар	4,935,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	-	8,320,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	8,320,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,859,032.00	72,303,947.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,909,200.00	72,303,947.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,305,332.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	277,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,367,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	162,992,325.90	223,257,662.83
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	162,992,325.90	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	162,992,325.90	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	223,257,662.83
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	223,257,662.83

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	424,824,825,706.56	424,824,825,706.56
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	424,824,825,706.56	424,824,825,706.56
9	Тайлант үеийн үр дүн	-	220,269,418,924.79	220,269,418,924.79
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	645,094,244,631.35	645,094,244,631.35
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	645,094,244,631.35	645,094,244,631.35
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	29,103,264,419.61	29,103,264,419.61
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	674,197,509,050.96	674,197,509,050.96

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

САГ-2026/61/НА-СТА-ТХН

Тайлант хугацаа: 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,398,093,300.00	1,296,270,337.17	101,822,962.83	92.7
12	Татварын бус орлого	1,398,093,300.00	1,296,270,337.17	101,822,962.83	92.7
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,296,270,337.17	(1,296,270,337.17)	
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	1,296,270,337.17	(1,296,270,337.17)	
122	Тусламжийн орлого	1,398,093,300.00	-	1,398,093,300.00	0.0
122005	Төсвөөс санхүүжих	1,398,093,300.00	-	1,398,093,300.00	0.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,398,093,300.00	1,296,270,337.17	101,822,962.83	92.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,398,093,300.00	1,296,270,337.17	101,822,962.83	92.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,398,093,300.00	1,296,270,337.17	101,822,962.83	92.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	974,394,000.00	964,260,349.66	10,133,650.34	99.0
210101	Үндсэн цалин	974,394,000.00	964,260,349.66	10,133,650.34	99.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,799,300.00	116,911,864.29	4,887,435.71	96.0
210201	Тэтгэврийн даатгал	82,823,500.00	79,500,067.72	3,323,432.28	96.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,743,900.00	9,352,949.14	390,950.86	96.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,872,000.00	4,676,474.57	195,525.43	96.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,872,000.00	4,676,474.57	195,525.43	96.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,487,900.00	18,705,898.29	782,001.71	96.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,048,000.00	117,047,941.22	58.78	100.0
210304	Байрны түрээс	117,048,000.00	117,047,941.22	58.78	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	18,548,000.00	17,426,235.00	1,121,765.00	94.0
210401	Бичиг хэрэг	6,048,000.00	5,289,300.00	758,700.00	87.5
210402	Тээвэр, шатахуун	8,500,000.00	8,461,420.00	38,580.00	99.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,500,000.00	2,400,015.00	99,985.00	96.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,275,500.00	224,500.00	85.0
2107	Томилолт, зочны зардал	94,000,000.00	8,320,000.00	85,680,000.00	8.9
210701	Гадаад албан томилолт	85,500,000.00	-	85,500,000.00	0.0

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	8,500,000.00	8,320,000.00	180,000.00	97.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,304,000.00	72,303,947.00	53.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72,304,000.00	72,303,947.00	53.00	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	101,822,962.83	101,822,962.83	
9	АЛДАГДАЛ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(101,822,962.83)	101,822,962.83	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	17	15	2	
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	14	12	2	
620003	Үйлчлэх ажилтан	2	2	-	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн өртөг 262,700.0 мянган ам.доллар бөгөөд 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс барьж, байгуулж эхэлсэн. Энэхүү төсөл нь 250,000м³/хоног бохир усыг цэвэршүүлж Монгол Улсын хүрээлэн буй орчинд нийлүүлэх усны стандарт /MNS:4943-2015/-ын шаардлагад нийцүүлж, Туул голд нийлүүлэх зорилготой.

Одоогийн байдлаар төв цэвэрлэх байгууламж нь нийт хүчин чадлын 20.0 хувиар ажиллаж байна. Учир нь:

1. Цэвэрлэх байгууламжид нийлүүлэгдэх усны стандарт MNS 6561-2015 стандартад заагдсан бохирдлын хэмжээ 2-4 дахин өндөр байгаа тул усны хэмжээгээ нэмэгдүүлбэл одоогийн цэвэрлэх процессын чанар муудах эрсдэл байна.
2. Орж ирж буй усны бохирдол их байхад хүлээн авч буй усны хэмжээгээ нэмэгдүүлэхэд химийн бодисын хэрэглээ нэмэгдэж зардал өсөхөөр байна.

Тухайлбал хамгийн оргил үедээ өдрийн 90,000.0 мянган төгрөг хүртэл зардал нэмэгдэх тооцоололтой байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл нь Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага бөгөөд үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Сангийн сайдын гаргасан тушаал шийдвэр, болон бусад холбогдох хууль, дүрэм журмуудыг дагаж мөрддөг байна.

Тайлант хугацаанд төслийн санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн зохицуулагчийн 2020 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг дагаж мөрддөг бөгөөд бодлогын баримт бичиг нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,103,534.4 мянган төгрөг буюу 4.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	806.9	0.0	(806.9)
Урьдчилгаа	32,734,111.8	10,488,760.0	(22,245,351.8)
Бараа материал	101,470.8	7,138.2	(94,332.6)
Нөөцийн бараа	612,138,360.5	663,631,820.2	51,493,459.7
Үндсэн хөрөнгө	119,494.6	70,060.6	(49,433.9)
Нийт хөрөнгө	645,094,244.6	674,197,779.1	29,103,534.4
Өр төлбөр	0.0	270.0	270.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	645,094,244.6	674,197,509.1	29,103,264.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	645,094,244.6	674,197,779.1	29,103,534.4

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Урьдчилгаа дансны үлдэгдэл 10,488,760.0 мянган төгрөг болж, 22,245,351.8 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 7,138.2 мянган төгрөг болж, 94,332.6 мянган төгрөгөөр буурсан нь 92,084.5 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 70,060.6 мянган төгрөг болж, 49,433.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд байгуулсан 49,433.9 мянган төгрөгийн элэгдэл нөлөөлсөн.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 29,103,264.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалсан байна.

Судалгааны үр дүн:

Тус төслийн программ хангамжийн дансанд бүртгэлтэй 2019-2023 онуудад худалдан авч ашиглаж байгаа 924.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программ, 2,670.0 мянган төгрөгийн төсөвчний программуудтай байна. Тайлант онд программ хөгжүүлэхтэй холбоотой зардал гараагүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1,590,600.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналд өөрчлөлт оруулаагүй хэвээр баталсан байна.

Төсвийн тодотголоор урсгал зардлыг 192,506.7 мянган төгрөгөөр бууруулж, 1,398,093.3 мянган төгрөгөөр баталсан. Энэ нь гадаад сургалтыг зохион байгуулахгүй болсон, төсвийг бодитой төлөвлөөгүйтэй холбоотой юм.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,398,093.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 101,823.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,296,270.3 мянган төгрөг буюу 92.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 10,133.4 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 4,887.4 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 1,121.8 мянган төгрөгөөр, томилолт зочид хүлээн авах зардлыг 85,680.00 мянган төгрөгөөр, нийт 101,823.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
70207	Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	1,398,093.3	1,296,270.3	101,823.0	92.7
83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал	1,398,093.3	1,296,270.3	101,823.0	92.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Судалгааны үр дүн:

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгасан. Үүнд

1. *Байгууллагын орон тооны цомхотголын талаар:* Тайлант онд 17 орон тоо батлагдсан боловч 9 хувийн цомхотгол хийж, гүйцэтгэлээр 15 орон тоотой ажиллаж байна.
2. *Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны үр дүнгийн талаар:* Гадаад томилолт, арга хэмжээний хувьд 85,500.0 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр зарцуулалт гараагүй.
3. *Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүнгийн талаар:* сургалтын үйл ажиллагаанд 2,300.0 мянган төгрөгийг төлөвлөж гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан.
4. *Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгааны үр дүнгийн талаар:* Хэвлэл мэдээллийн “Нейшнлфильм прожест” ХХК-тай 11,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий контент бүтээх гэрээ байгуулж, ажилласан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлаагүй.

Гүйцэтгэлээр төсөл боловсруулах, төсөвт хяналт тавих ажил гүйцэтгэх 02 дугаартай 25,000.0 мянган төгрөгийн төсөвтэй гэрээг 2025 оны 8 дугаар сарын 15-ны өдөр САГ-2026/61/НА-СТА-ТХН

шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн зөрчил илэрсэнд албан шаардлага өгсөн.

3.5.5 Төсөл, хөтөлбөрийн үр дүн

Энэхүү төслийн хүрээнд 2019 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 337 дугаар тогтоолоор 22 га талбайд шинэ цэвэрлэх байгууламж барихаар шийдвэрлэсэн. Уг төсөл нь 2019-2023 онуудад зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлыг бүрэн дуусгаж хүлээлгэн өгөхөөр төлөвлөгдсөн боловч 2020-2022 оны ковид-19 цар тахлын улмаас ажлын гүйцэтгэл удааширсан байна.

Иймээс 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр улсын комисст гадна цахилгаан хангамжийн байгууламжийг, 9 дүгээр сарын 29-ний өдөр бүрэн хэмжээгээр техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.

Одоогийн байдлаар хоногт 50,000м³ ахуйн хүрээний бохир ус хүлээн авч цэвэршүүлж, Туул голд нийлүүлж байгаа бөгөөд тус цэвэрлэх байгууламж нь бүрэн хүчин чадлаар ажиллахад хоногт 180,000.0 мянган төгрөгийн ашиглалтын зардал гарахаар тооцоололтой байна. Хаягдал лагийг боловсруулалт хийж дотооддоо ашиглахад цагт 3600 кв цахилгаан эрчим хүч үйлдвэрлэснээр өдөрт 23,800.0 мянган төгрөгийн зардлын хэмнэлт үүсэхээр байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ариун төгс оршихуй аудит ХХК-ийн аудитор Ч.Сэлэнгэ, Р.Оюунбат, Д.Сүхбаатар нар гүйцэтгэж, аудитын чанарын хяналтын менежер С.Эрдэнэчимэг, компанийн захирал Г.Баялаг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Долгоржав, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ариун төгс оршихуй аудит ХХК-нд 2025 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны үр дүнгийн тайлангийн зардлын 1,478,276.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,782.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага ямар нэгэн тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст 154 мэдээлэл ил тод байршуулахаас 135 мэдээллийг хугацаандаа, 675,682.2 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 13 мэдээллийг хугацаа хоцроож, 9,092.9 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 1 мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2.2.1.13-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, зарлагын гүйлгээ бүр, холбогдох шийдвэрийн хуулбарын хамт", 2.2.2.5-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, орлого, зардлын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар илэрсэн 4,657.8 мянган төгрөгийн цалинг зөрүүтэй тооцсон алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1	-	1	-	-
Нийт дүн	1	-	1	-	-

Өмнөх оны аудитаар санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 102,118.5 мянган төгрөгийн үнэ бүхий машин тоног төхөөрөмжийн 24 нэр төрлийн 84 ширхэг хөрөнгийг цаашид хэрхэн ашиглах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шатах тослох материал дансанд бүртгэлтэй шатахууны картын үлдэгдэл 7,138.2 мянган төгрөгийн зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 39,932.5 мянган төгрөгийн 5 зөрчил илэрсэнд 2,722.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 33,000.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 4,210.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 39,932.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 14,782.8 мянган төгрөгөөс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Тус байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр хүртэл ажиллаж ажлаас чөлөөлөгдөх шийдвэр гарсан санхүүгийн ажилтанд 5 дугаар сард бүтэн ажилласнаар тооцож, 2,722.5 мянган төгрөгийн цалин илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү бодож олгосон цалинг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Төсөл боловсруулах, төсөвт хяналт тавих ажил гүйцэтгэх 25,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авах арга хэмжээнд харьцуулалтын арга хэрэглэлгүй шууд гэрээ байгуулж, тендерийн босго үнэ мөрдөөгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т “Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ”, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” гэсэн заалтууд, Засгийн газрын 2024 оны Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөв өртгийн дээд хязгаар тогтоох тухай 02 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа ажил үйлчилгээний төсөвт өртгийг дээд хязгаарыг тус тус мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд худалдан авсан шатахууны 8,000.0 мянган төгрөгийн зарцуулалт нь жолоочийн тооцооны хуудсаар баталгаажуулаагүй буюу анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дүгээр зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, САГ-2026/61/НА-СТА-ТХН

гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн тооцооны хуудсаар баталгаажуулаагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар шатахуун зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

3. Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 24 нэр төрлийн 84 ширхэг хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад санал хүргүүлж, ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ аваагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дүгээр зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", 7.2-т "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталж, данснаас хасахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авсан боловч ашиглалтын шаардлага хангаж байгаа, дахин ашиглах боломжтой хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн тогтоож, дахин данс бүртгэлд тусгана", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэсэн заалтад тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ өртгөө нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ авах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйл үйлчилгээний зардал (210801) дансанд засвар үйлчилгээ, бичиг хэрэг, бараа үйлчилгээний бусад зардалд хамаарах 4,210.0 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал зөрчин тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаал "Ангилал шинэчлэн батлах тухай" журмын хамаарах заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох дээд шатны байгууллагаас зөвшөөрөл авч, гүйцэтгэлийг бодитой тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсөл боловсруулах, төсөвт хяналт тавих ажил гүйцэтгэх 25,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авах арга хэмжээнд харьцуулалтын арга хэрэглэлгүй шууд гэрээ байгуулж, тендерийн босго үнэ мөрдөөгүй байна	1	25,000.0			1	25,000.0						
2	Тус байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр хүртэл ажиллаж ажлаас чөлөөлөгдөх шийдвэр гарсан санхүүгийн ажилтанд 5 дугаар сард бүтэн ажилласан байдлаар цалин тооцож олгосон.	1	2,722.5	1	2,722.5								
3	Жолоочийн тооцооны хуудсаар баталгаажуулаагүй 8,000.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.	1	8,000.0			1	8,000.0						
4	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйл үйлчилгээний зардал (210801) дансанд засвар үйлчилгээ, бичиг хэрэг, бараа үйлчилгээний бусад зардалд хамаарах 4,210.0 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал зөрчин тайлагнасан.	1	4,210.0					1	4,210.0				
5	Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 24 нэр	1	0			1	0						

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	төрлийн 84 ширхэг хөрөнгийг цаашид хэрхэн ашиглах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.											
Дүн		5	39,932.5	1	2,722.5	3	33,000.0	1	4,210.0			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны цахим хуудаст 154 мэдээлэл ил тод байршуулахаас 135 мэдээллийг хугацаандаа, 675,682.2 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 13 мэдээллийг хугацаа хоцроож, 9,092.9 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 1 мэдээллийг байршуулаагүй байна.	1	-	1	-		
	Нийт дүн	1	-	1	-		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 548/А0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/61/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөл боловсруулах, төсөвт хяналт тавих ажил гүйцэтгэх 25,000,000.00 /хорин таван сая/ төгрөгийн төсөвт өртөгтэй, худалдан авах арга хэмжээнд шууд гэрээ байгуулж, харьцуулалтын арга хэрэглээгүй, тендерийн босго үнэ мөрдөөгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1-д "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" заалтууд, Засгийн газрын 2024 оны Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай 02 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг тус тус мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн хязгаарыг мөрдөөгүй, харьцуулалтын арга хэрэглээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны нэгдсэн төслийн нэгжийн Ерөнхий инженер /Г.Чулуунбат/, санхүүгийн ажилтан /Г.Энхцацрал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ"
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Г.БАЯЛАГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 549/АД150185

Улаанбаатар хот

САГ - 2026/61/МА - СТА - ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд худалдан авсан шатахууны 8,000,000.00 /найман сая/ төгрөгийн зарцуулалт нь жолоочийн тооцооны хуудсаар баталгаажуулаагүй буюу анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дүгээр зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.-1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Жолоочийн тооцооны хуудсаар баталгаажуулаагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар шатахуун зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны нэгдсэн төслийн нэгжийн Ерөнхий инженер /Г.Чулуунбат/, санхүүгийн ажилтан /Г.Энхцацрал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ"
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Г.БАЯЛАГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 551/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/61/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст 154 мэдээлэл ил тод байршуулахаас 135 мэдээллийг хугацаандаа, 675,682,175.00 /зургаан зуун далан таван сая зургаан зуун наян хоёр мянга нэг зуун далан таван/ төгрөгийн 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй орлого, зарлагын 13 мэдээллийг хугацаа хоцроож, 9,092,900.00 /есөн сая ерэн хоёр мянга есөн зуун/ төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2.2.1.13-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, зарлагын гүйлгээ бүр, холбогдох шийдвэрийн хуулбарын хамт", 2.2.2.5-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны нэгдсэн төслийн нэгжийн Ерөнхий инженер /Г.Чулуунбат/, санхүүгийн ажилтан /Г.Энхцацрал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Г.БАЯЛАГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 550/A0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/61/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 24 нэр төрлийн 84 ширхэг хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад санал хүргүүлж, ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ аваагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дүгээр зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", 7.2-т "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталж, данснаас хасахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авсан боловч ашиглалтын шаардлага хангаж байгаа, дахин ашиглах боломжтой хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн тогтоож, дахин данс бүртгэлд тусгана", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Элэгдлээрээ өртгөө нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ авч зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны нэгдсэн төслийн нэгжийн Ерөнхий инженер /Г.Чулуунбат/, санхүүгийн ажилтан /Г.Энхцацрал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
“АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ”
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Г.БАЯЛАГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 119/A0150185

Улаанбаатар хот

САГ-20 26/61/НА-СТА-ПШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагад 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр хүртэл ажиллаж ажлаас чөлөөлөгдөх шийдвэр гарсан санхүүгийн ажилтанд 5 дугаар сард бүтэн ажилласнаар цалин тооцож 2,722,500.00 /Хоёр сая долоон зуун хорин хоёр мянга таван зуун/ төгрөг илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, аслага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цалин хөлс илүү бодож олгосон 2,722,500.00 /Хоёр сая долоон зуун хорин хоёр мянга таван зуун/ төгрөгийг Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Нэгдсэн төслийн нэгжийн Ерөнхий инженер /Г.Чулуунбат/, Санхүүгийн Зөвлөх /Д.Цэцэгмаа/ нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны нэгдсэн төслийн нэгжийн Ерөнхий инженер /Г.Чулуунбат/, санхүүгийн ажилтан /Ш.Энхцацрал/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Г.БАЯЛАГ